



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/858

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дүгээр сарын 13-ны өдрийн 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Энэ захирамжийн хавсралтад заасан нийт 214,950,000.00 (хоёр зуун арван дөрвөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 55,687,500.18 (тавин таван сая зургаан зуун наян долоон мянга таван зуун төгрөг арван найман мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй 6 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2. Хавсралтад заасан нийт 214,950,000.00 (хоёр зуун арван дөрвөн сая есөн зуун тавин) төгрөгийн бүртгэлийн үнэтэй 6 тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110204036



НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

ДД	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үндэслэсэн но	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Суудлын тээврийн хэрэгсэл	Хьюндай Элентра	64-09 УНР	КМННД41СВС U476052	2012 2012	1	29,800,000.00	29,800,000.00	-	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	ХУД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар
2	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёото Кроун	60-09 УНУ	GRS1800047800	2006 2013	1	21,600,000.00	20,610,000.00	990,000.00	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Шүүхийн ерөнхий зөвлөл
3	Суудлын тээврийн хэрэгсэл	Тоёота приус	21-27 БРА	ZWV305170472	2010 2015	1	16,000,000.00	16,000,000.00	-	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Шүүхийн ерөнхий зөвлөл
4	Суудлын тээврийн хэрэгсэл	Toyota Harrier	06-57 УНР	ACU300108680	2009 2018	1	34,950,000.00	17,475,000.00	17,475,000.00	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Шүүхийн ерөнхий зөвлөл
5	Суудлын тээврийн хэрэгсэл	Киа оптима	03-55 УНУ	KNAGT411BK 5315926	2018 2018	1	70,900,000.00	33,677,499.82	37,222,500.18	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн газар
6	Суудлын тээврийн хэрэгсэл	Хьюндай Старекс	09-95 УАС	КМЈWA37KAD U553486	2013 2013	1	41,700,000.00	41,700,000.00	-	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 407-р нээлттэй хаалттай хорих анги
Нийт дүн									55,687,500.18	-	-